

МӨНГӨНИЙ ТОЙМ

2016 оны 8 дугаар сар

ХУРААНГУЙ:

- Тайлант сард мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас -0.5 хувь, өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар өсч 11259.0 тэрбум төгрөг байна.
- Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 12.3 хувь буюу 889.8 тэрбум төгрөгөөр өсч 8107.5 тэрбум төгрөг болов.
- Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсч, 19.1 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 83.7 хувь нь хэвийн, 10.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 5.9 хувь нь чанаргүй зээл байна.
- Тайлант сард улсын болон Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт сөрөг болж, дефляцитай гарлаа. Үүнд хүнсний ногооны үнэ 18.6 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.


МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015		2016			
	8-р сар	12-р сар	3-р сар	6-р сар	7-р сар	8-р сар
М2 мөнгө, тэрбум ₮	9,964.4	10,050.2	10,113.7	11,188.2	11,310.8	11,259.0
<i>сарын өөрчлөлт, %</i>	1.0	2.5	1.0	5.0	1.1	-0.5
<i>жилийн өөрчлөлт, %</i>	-1.7	-5.5	2.1	11.4	14.7	13.0
Бусад хадгаламж, тэрбум ₮	8,282.5	8,364.8	8,530.0	9,206.8	9,370.0	9,352.8
<i>сарын өөрчлөлт, %</i>	0.9	1.4	0.4	3.3	1.8	-0.2
<i>жилийн өөрчлөлт, %</i>	0.3	-5.2	0.9	9.9	14.2	12.9
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮	774.4	706.7	658.6	839.2	818.2	817.2
<i>сарын өөрчлөлт, %</i>	2.0	-0.5	0.5	6.5	-2.5	-0.1
<i>жилийн өөрчлөлт, %</i>	-12.0	-12.7	-6.3	11.0	7.8	5.5
Нөөц мөнгө, тэрбум ₮	2,825.0	2,459.6	2,360.7	3,526.1	3,231.3	3,257.5
<i>сарын өөрчлөлт, %</i>	-5.1	17.9	2.3	10.0	-8.4	0.8
<i>жилийн өөрчлөлт, %</i>	0.4	-28.2	-4.4	49.9	8.5	15.3
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	17,603.2	17,932.8	18,430.3	18,429.5	18,626.3	19,148.2
<i>сарын өөрчлөлт, %</i>	1.0	0.5	1.5	1.7	1.1	2.8
<i>жилийн өөрчлөлт, %</i>	17.3	10.9	11.5	8.2	8.4	8.8
Чанаргүй зээл/Санхүүгийн байгууллагуудын зээл, %	4.92	4.85	5.25	5.62	5.53	5.88
Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, %	7.31	7.44	8.18	8.62	8.51	9.06
Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, % (Хадгаламж, Зоос банкиг хассанаар)	5.40	5.53	6.30	6.81	6.90	7.53
Хүү						
Хадгаламжийн ЖДХ	13.0	13.3	13.3	13.3	13.2	13.1
Тухайн сард олгосон зээлийн ЖДХ*	20.1	19.1	19.7	19.1	19.2	19.4
Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХ	10.0	8.8	8.8	7.7	7.7	8.4
ТБҮЦ-ны ЖДХ	13.0	13.0	12.0	10.5	10.5	12.3
Бодлогын хүү	13.0	13.0	12.0	10.5	10.5	15.0
БХЗ-ын ЖДХ	13.7	11.8	12.6	11.3	10.9	13.7
Инфляци						
Улаанбаатар хотын инфляци						
<i>сарын</i>	0.1	-0.2	0.3	-0.5	-1.0	-0.6
<i>оны эхнээс</i>	2.8	1.1	1.5	2.7	1.6	1.0
жилийн	5.9	1.1	1.1	1.2	0.1	-0.6
Суурь инфляци						
<i>сарын</i>	2.4	-0.1	-0.4	-0.1	0.0	0.3
<i>оны эхнээс</i>	2.9	4.8	-1.1	-1.2	-1.3	-1.0
жилийн	7.2	4.8	3.1	3.0	2.9	0.8
Улсын инфляци						
<i>сарын</i>	0.1	-0.2	0.5	-0.3	-0.6	-1.0
<i>оны эхнээс</i>	3.4	1.9	1.7	2.9	2.3	1.2
жилийн	6.6	1.9	1.7	1.6	0.9	-0.2

* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт


Зураг 1. Мөнгөний үзүүлэлтүүдийн жилийн өсөлт



Тайлант сард мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх сараас -0.5 хувь, оны эхнээс 12.0 хувь, өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар өссөн байна.


Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 2.3 нэгж хувийг M1 мөнгөний өсөлт, 10.7 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт бүрдүүлжээ. M1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.3 хувь буюу буюу 224.2 тэрбум төгрөгөөр өсч, M2 мөнгөний 16.9 хувийг эзэлж байна. Энэ нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.2 хувь, төгрөгийн харилцах 6.8 хувиар өссөнөөр тайлбарлагдаж байна.

Зураг 2. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Бусад хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.9 хувь буюу 1070.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийн 83.1 хувийг эзэлж байна. Үүнд төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 9.7 хувь буюу 492.8 тэрбум төгрөгөөр, гадаад валютын хадгаламж 18.5 хувь буюу 397 тэрбум төгрөгөөр, гадаад валютын харилцах 17 хувь буюу 180.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ. Мөнгөний нийлүүлэлтийн 49.5 хувийг төгрөгийн хадгаламж, 22.6 хувийг гадаад валютын хадгаламж, 11.7 хувийг төгрөгийн харилцах, 11.1 хувийг гадаад валютын харилцах, 5.2 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.

Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа (тэрбум ₮)



Тайлант сарын эцсийн байдлаар гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 817.2 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 228.5 тэрбум төгрөг касс дахь мөнгө, 588.7 тэрбум төгрөг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Хадгаламж

Зураг 4. Хадгаламж, түүний жилийн өсөлт



Нийт хадгаламж өмнөх сараас 1.2 хувь буюу 101.9 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 12.3 хувь буюу 889.8 тэрбум төгрөгөөр өсч 8107.5 тэрбум төгрөгт хүрэв.

Нийт хадгаламжийн 68.7 хувийг төгрөгийн, 31.3 хувийг гадаад валютын хадгаламж эзэлж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурсан байна.

Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй ч өмнөх оны мөн үеэс 19.6 хувь буюу 805 тэрбум төгрөгөөр өсч 4916.3 тэрбум төгрөгт хүрчээ. Байгууллагын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 20.3 хувь буюу 165.9 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 32.4 хувь буюу 312.2 тэрбум төгрөгөөр буурч 651.3 тэрбум төгрөг болов. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 2.7 хувь буюу 65.7 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 18.5 хувь буюу 397 тэрбум төгрөгөөр өсч 2539.8 тэрбум төгрөг хүрчээ.

Төгрөгийн харилцах өмнөх сараас 4.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсч 1317.5 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын харилцах өмнөх сараас 7.3 хувь, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өсч 1245.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Хүснэгт 1. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү, хувь

	Хадгаламж		Харилцах	
	Төгрөг	Валют	Төгрөг	Валют
Хүү	13.1	6.4	2.8	1.9
Жилийн өөрчлөлт	0.1	-0.1	-0.2	0.3

Хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсч 13.1 хувьтай байгаа бол валютын хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар буурч 6.4 хувьтай байна

Гадаад, дотоод цэвэр актив

Зураг 6. Гадаад, дотоод цэвэр актив




Тухайн сард Монгол улсын хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 15.1 хувь, оны эхнээс 0.4 хувь, өмнөх оны мөн үеэс 21.9 хувиар буурч -3920 тэрбум төгрөг болов.

Дотоод цэвэр актив өмнөх сараас 7.2 хувиар буурч, оны эхнээс 19.4 хувь, өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар өсч 7339 тэрбум төгрөг болжээ.

Нөөц мөнгө


Зураг 7. Нөөц мөнгө



Нөөц мөнгө өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны мөн үеэс мөн 15.3 хувиар өсч 3257.5 тэрбум төгрөг болжээ. Үүнд банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 18.9 хувь буюу 388.7 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 31.2 хувь буюу 139.9 тэрбум төгрөгөөр өсч, банкуудын касс 29.8 хувь буюу 96.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант сарын эцсийн байдлаар банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж нөөц мөнгөний 75 хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 18 хувь, банкуудын касс 7 хувийг тус тус эзэлж байна.

Зээл

Зураг 8. Зээлийн үлдэгдэл болон жилийн өөрчлөлт



Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сараас 1.9 нэгж хувь, өмнөх оны мөн үеэс 7.0 нэгж хувиар буурч жилийн 8.8 хувийн өсөлттэй байна.


Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сараас 2.8 хувь буюу 521.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 8.8 хувь буюу 1545 тэрбум төгрөгөөр өсч 19.1 их наяд төгрөг болжээ. Үүний 64.9 хувь буюу 12.4 их наяд төгрөгийг хадгаламжийн байгууллагуудын, 35.1 хувь буюу 6.7 их наяд төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл бүрдүүлж байна.

Санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээл өмнөх сараас 2.1 хувь буюу 156.9 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 8.4 хувь буюу 595.8 тэрбум төгрөгөөр өсч 7650.1 тэрбум төгрөгт хүрчээ. Хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 2.9 хувь буюу 214.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 7.8 хувь буюу 547.9 тэрбум төгрөгөөр өсч 7587.2 тэрбум төгрөг болжээ.


Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн 40 хувь нь иргэд, 39.6 хувь нь хувийн хэвшил, 20.4 хувь нь улсын байгууллагад олгосон зээл байна.

Нийт санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 83.7 хувийг хэвийн зээл, 10.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.9 хувийг

Зураг 9. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Зураг 10. Картын зээл



чанаргүй зээл тус тус эзэлж байна. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.3 нэгж хувь, чанаргүй зээлийнх 1.0 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн байгууллагуудын зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 9.1 хувь байгаа бөгөөд татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.5 хувийг эзэлж байна.

Банкуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон картын зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 1.7 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл 8 дугаар сарын байдлаар 212.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буюу 16.6 тэрбум төгрөгөөр буурчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд өмнөх сараас 2.7 хувиар буюу 5.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Картын зээлийн 89.4 хувь нь хэвийн, 3.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 6.7 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 92.3 хувь нь төгрөгөөр, 7.7 хувь нь валютаар олгогдсон байна.


Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч 19.4 хувьтай, гадаад валютаар олгосон зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өсч 13.3 хувьтай байна. Төгрөгийн зээлийн үлдэгдлийн хүү 18.4 хувь, гадаад валютын зээлийн хүү 11.6 хувь байна.

Зураг 11. Зээлийн жигнэсэн дундаж хүү, жилийн



Мөнгөний зах

Зураг 12. Банк хоорондын арилжааны хэмжээ, хүү




2016 оны 8 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 878.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Үүний 60.8 хувийг овернайт зээл, 19.7 хувийг Төв банкны үнэт цаас, 12.2 банк хоорондын хадгаламж, 7.3 хувийг репо арилжаа эзэлж байна. Банк хоорондын захын арилжааны жигнэсэн дундаж хүү 13.7 хувь байгаа нь өмнөх сараас 2.8 нэгж хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан байна.

Банкууд 2016 оны 8 сарын 3-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 1068 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцийг хангах зорилгоор дунджаар 1347.6 тэрбум төгрөг Төв банк дахь харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

Валютын ханш


Зураг 13. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, 2010.12.31 = 100



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны 8 дугаар сарын эцэст 2219.65 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2189.05 төгрөг байв. Тайлант сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2472.02, хятадын юаньтай харьцах ханш 332.31, японы иентэй харьцах ханш 21.49 төгрөг байлаа.

Инфляци

Зураг 14. Сарын инфляци



Улаанбаатар хотын сарын инфляци 2016 оны 8 дугаар сарын байдлаар -0.6 хувь, оны эхнээс 1.0 хувь, жилийнх -0.6 хувь байна. Хэрэглээний сагсны 30.0 орчим хувийг эзэлж буй хүнсний барааны үнэ өмнөх сараас 2.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурсан. Махны үнэ 2.4 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 1.8 хувиар буурч, сахар, чихэрний үнэ 2.4 хувиар өсчээ. Хүнсний барааны бүлэг сарын инфляцийн -0.8 нэгж хувийг эзэлж байгаа бөгөөд үүний -0.55 нэгж хувийг хүнсний ногооны үнийн өөрчлөлт бүрдүүлж байна.

Зураг 15. Жилийн инфляци



ХҮИ-ийн жилийн өөрчлөлтийн хувьд хүнсний ногооны үнэ 20.6 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 5.5 хувь, махны үнэ 4.7 хувиар буурчээ. Жимсний үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.5 хувь, сахар, чихэрний үнэ 4.8 хувь, согтууруулах бус ундааны үнэ 3.7 хувиар тус тус өссөн байна. Жилийн инфляцийн -0.9 нэгж хувийг хүнсний бараа эзэлж байгаа бөгөөд үүний -0.6 нэгж хувийг хүнсний ногоо, -0.5 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Хүнснээс бусад барааны үнэ өмнөх сараас 0.3 хувиар өссөн бөгөөд гэр ахуйн цахилгаан хэрэгслийн үнэ 4.5 хувь, сургалтын төлбөр 2.6 хувь, орон сууцны засварын хөлс 2.1 хувиар өсч, харин амбулаторийн үйлчилгээний

төлбөр 1.3 хувь, бичгийн хэрэгслийн үнэ 1.2 хувь, хувцас, гуталны үнэ 1.1 хувиар тус тус буурчээ. Хүнснээс бусад барааны үнийн өөрчлөлт сарын инфляцийн 0.2 нэгж хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 0.2 нэгж хувийг сургалтын зардал, 0.1 нэгж хувийг засвар, үйлчилгээ, -0.1 нэгж хувийг хувцас, гутал эзэлж байна.

Хүнснээс бусад барааны жилийн инфляци 0.4 хувь байгаагаас эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ 9.0 хувь, согтууруулах ундаа, тамхины үнэ 3.0 хувь, сургалтын төлбөр 2.6 хувь, гэр ахуйн тавилга, барааны үнэ 1.6 хувиар өсч, тээврийн зардал 1.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 0.6 хувиар тус тус буурчээ. Жилийн инфляцийн 0.3 нэгж хувийг эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, 0.2 нэгж хувийг боловсролын үйлчилгээ, -0.2 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, түлш, -0.2 нэгж хувийг тээврийн бүлгийн үнийн өөрчлөлт эзэлж байна.